



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/11/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,*

*Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: Ш.Мөнхцэцэг*

*Утас: 70003775,*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.1 Албан шаардлага .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 281  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
Т.БОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020051

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,495,590.00</u></b>	<b><u>3,624,890.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,495,590.00	3,624,890.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,495,590.00	3,624,890.00
35410	Бичиг хэргийн материал	2,581,590.00	2,090,890.00
35420	Аж ахуйн материал	1,914,000.00	1,534,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>30,678,147.65</u></b>	<b><u>28,060,794.97</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	30,678,147.65	28,060,794.97
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	30,678,147.65	28,060,794.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,800,000.00	24,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,133,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,707,000.00	13,553,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,828,852.35)	(6,158,871.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,571,539.00	13,191,539.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,571,539.00)	(13,191,539.00)
39301	Программ хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(200,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>35,173,737.65</u></b>	<b><u>31,685,684.97</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>35,173,737.65</u></b>	<b><u>31,685,684.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	35,173,737.65	31,685,684.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,170,000.00	5,170,000.00
51101	Өмч: - төрийн	5,170,000.00	5,170,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	30,003,737.65	26,515,684.97
51210	Өмнөх үеийн үр дүн	30,003,737.65	30,003,737.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,488,052.68)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>35,173,737.65</u></b>	<b><u>31,685,684.97</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,803,000,000.00	292,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,802,000,000.00	292,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	224,032,100.00	192,473,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,032,100.00	192,473,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,026,934,857.82</b>	<b>487,961,352.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,026,934,857.82</b>	<b>487,961,352.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,992,765,962.62	453,003,098.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	111,456,420.38	109,505,185.15
210101	Үндсэн цалин	87,385,500.38	85,299,791.15
210104	Урамшуулал	24,070,920.00	24,205,394.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,920,700.00	11,363,700.00
210201	Тэтгэврийн даатгал	7,418,100.00	7,804,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	700,500.00	711,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	875,700.00	889,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	175,100.00	178,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,751,300.00	1,779,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,630,416.42	8,075,520.00
210401	Бичиг хэрэг	3,038,800.00	2,163,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,990,000.00	4,740,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	473,616.42	304,920.00
210404	Ном, хэвлэл	128,000.00	186,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	680,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,462,500.00	2,653,000.00
210604	Урсгал засвар	1,462,500.00	2,653,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,802,693,280.00	281,428,635.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,802,693,280.00	281,428,635.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57,602,645.82	39,977,058.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,458,388.00	33,860,705.75
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,144,257.82	6,116,352.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34,168,895.20	34,958,254.10
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	31,000,000.00	31,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,000,000.00	31,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,680,000.00	1,680,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	1,680,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,488,895.20	2,278,254.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,488,895.20	2,278,254.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>97,242.18</b>	<b>(3,488,052.68)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>97,242.18</b>	<b>(3,488,052.68)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ҮР ДҮН	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,170,000.00	0.00	30,003,737.65	35,173,737.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>5,170,000.00</b>	<b>0.00</b>	<b>30,003,737.65</b>	<b>35,173,737.65</b>
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>5,170,000.00</b>	<b>0.00</b>	<b>30,003,737.65</b>	<b>35,173,737.65</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>5,170,000.00</b>	<b>0.00</b>	<b>30,003,737.65</b>	<b>35,173,737.65</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,488,052.68	-3,488,052.68
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>5,170,000.00</b>	<b>0.00</b>	<b>26,515,684.97</b>	<b>31,685,684.97</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,803,000,000.00	292,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,802,000,000.00	292,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	224,032,100.00	192,473,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,032,100.00	192,473,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,027,032,100.00</b>	<b>484,473,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,992,863,204.80</b>	<b>449,515,045.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	111,456,420.38	109,505,185.15
210101	Үндсэн цалин	87,385,500.38	85,299,791.15
210104	Урамшуулал	24,070,920.00	24,205,394.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,920,700.00	11,363,700.00
210201	Тэтгэврийн даатгал	7,418,100.00	7,804,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	700,500.00	711,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	875,700.00	889,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	175,100.00	178,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,751,300.00	1,779,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,364,916.42	7,204,820.00
210401	Бичиг хэрэг	2,151,300.00	1,415,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,990,000.00	4,740,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	473,616.42	304,920.00
210404	Ном, хэвлэл	750,000.00	744,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,969,500.00</b>	<b>6,152,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,982,000.00	3,499,000.00
210604	Урсгал засвар	1,987,500.00	2,653,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,802,693,280.00</b>	<b>281,428,635.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,802,693,280.00	281,428,635.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,458,388.00</b>	<b>33,860,705.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,458,388.00	33,860,705.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,168,895.20</b>	<b>34,958,254.10</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>31,000,000.00</b>	<b>31,000,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,000,000.00	31,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,680,000.00</b>	<b>1,680,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	1,680,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,488,895.20</b>	<b>2,278,254.10</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,488,895.20	2,278,254.10
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	192,473,300.00	190,195,045.90
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	192,473,300.00	190,195,045.90
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	159,793,300.00	157,515,045.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	109,871,600.00	109,505,185.15
210101	Үндсэн цалин	85,662,800.00	85,299,791.15
210104	Урамшуулал	24,208,800.00	24,205,394.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,563,700.00	11,363,700.00
210201	Тэтгэврийн даатгал	8,138,200.00	7,804,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	684,900.00	711,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	856,400.00	889,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	171,500.00	178,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,712,700.00	1,779,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,277,200.00	7,204,820.00
210401	Бичиг хэрэг	1,419,200.00	1,415,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,744,600.00	4,740,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	363,400.00	304,920.00
210404	Ном, хэвлэл	750,000.00	744,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,152,000.00</b>	<b>6,152,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,499,000.00	3,499,000.00
210604	Урсгал засвар	2,653,000.00	2,653,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>428,800.00</b>	<b>428,635.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	428,800.00	428,635.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,500,000.00	22,860,705.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,500,000.00	22,860,705.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32,680,000.00	32,680,000.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	31,000,000.00	31,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,000,000.00	31,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,680,000.00	1,680,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	1,680,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	192,473,300.00	190,195,045.90
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	192,473,300.00	190,195,045.90
132001	Орон нутгийн төсвөөс	192,473,300.00	190,195,045.90
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>292,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	292,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	281,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	281,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	292,000,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	292,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	292,000,000.00
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Ш.Мөнхцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь: Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 222,543.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,451.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,338.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 3,624.8 мянган төгрөг болж 871.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 51,744.5 мянган төгрөг болж 1,466.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь 3,499.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаар нэмэгдэн, 380.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил шилжүүлсэн, 1,653.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдсан дүнгээр хасагдсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,567,358.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан санхүүжилттэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1,538,973.5 мянган төгрөгөөр буурсан нь бараа үйлчилгээний зардал буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 192,473.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 192,473.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 192,473.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 192,473.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 192,473.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 192,473.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 190,195.0 мянган төгрөг буюу 98.8 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 2,278.3 мянган төгрөг буюу 1.2 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дорнод аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 292,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 11,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээний төлбөр хураамжийн зардалд 281,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 15 орлогын 95,232.2 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 зарлагын 6,500.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад

төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,800,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5,332.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,332.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

### **4.1 Албан шаардлага**

1. Тайлант онд 4 байгууллагаас 1,833.5 төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Анхан шатны дэмжих баримтгүй 3,499.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	5.3	-	-	-	-	3	5.3	-	-